

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 04 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

а/ Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр: Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас зохион байгуулан явуулдаг байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулах, мэдээ мэдээлэлээ ил тод шуурхай солилцох ажлын хүрээнд сар бүрийн ажлын эхний өдөр “УДИРДАХ АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙН ЦАГ”-ыг 2023 оын 04 сарын 03-ны өдөр хуралдаж сумын нийт албан байгууллагуудын дарга эрхлэгч нартай уулзан мэдээлэл солилцон одоогийн цаг үеийн байдал болоод ирэх сард хийхээр төлөвлөж байгаа ажлуудын талаар санал солилцон ажилласан.

Мөн сумын ИТХ-ын ээлжит 14 дүгээр хуралдаан 04 сарын 04-ны өдөр хуралдаж дараах 3 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

1. Сумын 2023 оны төсөвт тодотгол хийх тухай
2. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороо болон тэргүүлэх чиглэл батлах тухай
3. Халзан-Дулаан ОНӨААТҮГ-ын ажилчдын цалинг шинэчлэн тогтоох санал батлах тухай

Монголын Нутгийн удирлагын холбооны ИТХ-ын нарийн бичгийн дарга нарыг чадавхжуулах 2 өдрийн сургалтад ИТХ-ын нарийн бичиг М.Сонинбаяр хамрагдсан.

Сүхбаатар аймгийн архивийн тасгаас албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон монгол бичгийн фонд ашиглалтын талаарх сургалтыг 4 сарын 20,21-ны өдрүүдэд зохион байгуулж уг сургалтад бичиг хэргийн ажилтан болон мэргэжилтэн нар хамрагдсан.

АИТХ-аас сар болгоны 25-ны өдрийг “Залуучуудын” өдөр болгон зарласаны дагуу сумын эрүүл мэндийн төвтэй хамтран “Эрүүл идэхтай амьдрал” аяны хүрээнд 4 сарын 22-ны өдөр 2 төрөлт спортын арга хэмжээн зохион байгуулсан.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч, Санхүү албаны даргыг түр орлон гүйцэтгэгч нарын ХАСУМ ыг АТГ -т хянуулж засаг даргын захирамжаар томилгоожуулан ажиллалаа.

Хоршоо хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар батлуулан ажиллалаа.

Е- Mongolia: Цахим системээс Иргэний үнэмлэхийн лавлагаа – 3, жолооны үнэмлэх солих, нөхөн олгох – 1, жолооны үнэмлэхийн лавлагаа-1, нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт – 7, иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа – 2, вакцины гэрчилгээ – 1, нийт - 15 лавлагаа олголоо.

ERP: системд Төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны дундын системд хандаж байгууллагаа бүртгүүлэн токен үүсгэн авч үйл ажиллагаандаа ашиглаж байгаа дотоод удирдлагын нэгдсэн систем(ерп)-д холболт хийх арга хэмжээг авсан.

Пэйж хуудсанд энэ сар нийт 25 пост(мэдээ мэдээлэл) оруулсан. Халзан сумын албан ёсны вэб сайт болох Khalzan.su.gov.mn хандах эрхийг олж авч веб сайтны хөгжүүлэлт болон нэмэх зүйл дээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ХНУМС-д төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон цалингийн өөрчлөлт, төрийн захиргааны албан хаагчийн ангилал зэрэглэлийг шинэчлэн орууллаа.

4-р дүгээр сард нийт ирсэн бичиг 11, хариутай -6, үүнээс хугацаанд нь илгээсэн - 5, хугацаа болоогүй -1, явсан бичиг -8 байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:

4 дугаар сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 59.2 сая төгрөг авч орон нутгийн төсвийн байгууллагуудад 136.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн программд 2024 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг оруулж иргэдээс саналыг цахимаар авах ажлыг хийж эхэллээ.

Төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагаар шалгуулж “Өөрчлөлтгүй” дүгнэлтийг авсан.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн пүрэв гаригт цахимаар зохион байгуулагддаг сургалтад нийт 16 албан хаагчдыг хамруулж ажиллалаа.

ХАБЭА-н сарын аяны хүрээнд сумын хэмжээнд төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд ХАБЭА н чиглэлээр ЗДТГ болон Соёлын төв албан хаагчдадаа хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулан ажиллав. .

Сүхбаатар аймгийн архивийн тасгаас албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон монгол бичгийн фонд ашиглалтын талаарх сургалтыг 4 сарын 20,21-ны өдрүүдэд зохион байгуулж уг сургалтад бичиг хэргийн ажилтан болон мэргэжилтэн нар хамрагдсан.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Ерөнхий боловсролын сургууль: Сүхбаатар суманд 4 сарын 15,16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан U-15 насны "Аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд тус сургуулийн баг тамирчид амжилттай оролцож Хөвгүүдийн баг 3-р байр хүрэл медаль, 9-р ангийн сурагч 3.Болд – Эрдэнэ шилдэг холбогчоор шалгарсан амжилттай байна.

Аймгийн сэтгэх чадварын олимпиадад амжилттай оролцож 1-р ангийн сурагч Э.СОНДОР тусгай байр ,1-р ангийн сурагч Б.АМИН-ЭРДЭНЭ тусгай байр ,3-р ангийн сурагч О.БИЛГҮҮНТӨГС тусгай байр тус тус эзэлсэн байна.

Хүүхдийн спортын анхдугаар наадамд Хөлбөмбөгийн төрөлд тус сургуулийн сурагчид "Хүрэл" медаль хүртсэн.

4-р сарын 20,21-ны өдрүүдэд “Сайн багшийн сайн технологи” ур чадварын хичээлийн 1-н давааг амжилттай зохион байгуулж байна. Уралдаанд бага ангийн багш нар монгол хэлний хичээлээр, дунд ангийн багш нар нийгмийн ухаан, байгалийн ухаан гэсэн хичээлийг зааж байна.

Нийгмийн ажилтан Э.Жавзандулам 4-р сарын 20-21-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо үндсэн сургалтанд хамрагдаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн төв нь 4 сард Хөдөөгийн 3 багийн ард иргэдэд артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгийг Багийн даргатай хамтран нийт 125 иргэнийг өнөөдрийн байдлаар хамруулан эрсдэлт бүлгийн хүмүүсийг хяналтандаа авч сэргээн засах болон өдрийн эмчилгээнд хамруулан ажиллаж байна.

2023 оны 04 сарын 19 нд Эрүүл мэндийн төвийн Дарга Сумын Засаг даргатай хамт Эрүүл мэндийн салбарын Удирдах ажилтны хуралд оролцсон

Эрүүл мэндийн төвийн ажилчид АНЭ-т урьдчилан сэргийлэх үзлэгтээ 2 хуваагаад үзүүлж цээжны рентген зураг авахуулан үзлэг шинжилгээндээ хамрагдсан

Мал эмнэлэгийн чиглэлээр: Орон нутгийн гаралтай халдварт “ шөвөг яр, боом, галзуу” өвчний вакцинйг аймгийн мал эмнэлгийн газраас татан авч дархлаажуулалтын ажилыг хийж гүйцэтгэв. Мөн шүлхий өвчний тандалтанд 4 баг тус бүрээс нэг нэг өрх сонгон 12 сартай өсвөр 56 малаас цусний дээж аван мал эмнэлгийн лабораторид хүргэж өгсөн. Сэг зэм устгах ариутгал халдваргүйтгэлийн хүрээнд 2-р багийн малчид иргэдтэй хамтарч өвөлжөөний газрын ойр орчмын 65 малын сэг зэмийг аймгийн хогийн цэгт хүргэж устгуулж ариутгал хийв.

Байгаль орчны чиглэлээр: Ар булаг дэлгүүрийн үүдэн дэхь ус зайлуулах хоолойн усыг “Ханан салхит” компаний ажилчдаар юүлүүлэх ажлыг зохион байгуулав.

“Сэг зэм” устгал” төсөл бичиж хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлэн батлагдаад ирсэн, Сэг зэм устгах ажлын хэсгийг байгуулж нэгдсэн хогийн цэг дээр хаясан сэг зэмийг цуглуулан нүхэнд хийж ариутгал халдваргүйжилт хийж булж устгах ажлыг зохион байгуулав.

Гамшгаас үеийн нүүлгэн шилжүүлэлтэнд ажиллах хүн хүч техник хэрэгслийн судалгаа, орон байрны судалгаа, цугларах талбайн судалгааг гаргаж аймгийн ОБГ-т хүргүүлэв

Ундны ус түгээх цэг болон халуун усны судалгааг гаргаж аймгийн Газрын албанд хүргүүлэв.

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:
М.ХУЯГ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Д.ДАЙРИЙМАА

